


# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

09.28 - 10.02



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** АНУ-ын зах зээлийн үнэлгээ ихтэй компаниудаас бүрддэг индексүүд дөрвөн долоо хоног дараалан буурсны эцэст энэ долоо хоногт өсөлт үзүүлээ. S&P 500 индексийн сагсанд багтах ихэнх салбарын компаниуд өсөлттэй байсан ч эрчим хүчний салбар уналттай байлаа.

Энэ долоо хоногийн хөрөнгийн зах зээлийн өсөлтөд улс төрийн орчин ихээхэн нөлөө үзүүлжээ. Эдийн засгийг дэмжих нэмэлт арга хэмжээтэй холбоотой АНУ-ын Сангийн яамны нарийн бичгийн дарга Стивен Мнучин, танхимын дарга Нэнси Пелоси нар эдийн засгийг дэмжих хөтөлбөртэй холбоотой эсрэг утгатай мэдэгдэл хийсэн нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байсан ч Мягмар гарагт АНУ-ын Бүгд найрамдах намаас эдийн засгийг дэмжих 1.6 их наяд ам.доллар хүртэлх дүнтэй хөтөлбөр батлахад бэлэн байгаагаар илэрхийлсэн нь хөрөнгийн зах зээлд эергээр нөлөөлжээ. Лхагва гарагт Пелоси тохиролцоонд хүрнэ гэж найдаж байгаагаар илэрхийлсэн бол Мнучин хөтөлбөрийг батлуулахын тулд дахин нэг оролдлого хийнэ гэж мэдэгджээ.

**Европ:** Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Европын хөрөнгө оруулагчид уналтад орсон байсан компаниудын тэр дундаа санхүүгийн салбарын компаниудыг ихээр сонирхож эхэлсэн байна. Гэхдээ АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп ба түүний эхнэр коронавирусын халдвар авсан гэх мэдээнээс үүдэн өсөлтүүд хязгаарлагдсан байна. STOXX Europe 600 индекс 2.02%-аар, Xetra DAX индекс 1.76%-аар, CAC 40 индекс 2.01%-аар, FTSE MIB индекс 1.96%-аар, FTSE 100 индекс 1.78%-аар тус тус өссөн байна.

Евро бүсийн гол бондын өгөөжүүд бууралттай байсан ба ялангуяа коронавирусын халдварын тоо дахин нэмэгдсэнтэй холбоотой эдийн засгийн сэргэлтийн удаашрал болон инфляцын хэт бага түвшинтэй холбоотойгоор ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж хамгийн их бууралттай байлаа. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн төлөөх мэтгэлцээнээс үүдсэн улс төрийн тогтворгүй байдал болон АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп коронавирусын халдвар авсан нь мөн бондын өгөөжүүдэд сөргөөр нөлөөлжээ.

**Япон:** Арилжааны дөрвөн өдөртэй байсан энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. 2020 оны 10-р сарын 1-ний Пүрэв гарагт Токиогийн Хөрөнгийн Бирж дээр техникийн саатал үүссэнтэй холбоотой арилжаа бүтэн өдөр зогссон байна. Nikkei 225 индекс 175 нэгжээр буюу 0.75%-аар буурч 23,029.90 нэгж дээр хаагдсан нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 2.7%-ийн бууралт юм. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэх large-cap TOPIX болон TOPIX small индексүүд мөн бууралттай хаагджээ.

**БНХАУ:** БНХАУ-ын эдийн засгийн зарим нэг үзүүлэлтүүд эдийн засгийн сэргэлт зогсоогүй байгааг харуулсан нь БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бага зэрэг өсөлттэй хаагдахад нөлөөлжээ. Гэхдээ БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 9-р сарын эцсийн байдлаар 2019 оны 5-р сараас хойших хамгийн их бууралтыг үзүүлжээ. Удахгүй болох БНХАУ-ын Ant Group-ийн IPO-той холбоотойгоор БНХАУ-ын технологийн салбарын компаниуд хамгийн их өсөлттэй байлаа.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,589.16	0.11% ▲
Dow Jones	АНУ	27,682.81	1.87% ▲
S&P 500	АНУ	3,348.44	1.52% ▲
Nasdaq	АНУ	11,075.02	1.48% ▲
S&P/TSX	Канад	16,199.25	0.83% ▲
FTSE 100	Их Британи	5,902.12	1.02% ▲
S&P/ASX 200	Австрали	5,791.50	-2.91% ▼
Nikkei 225	Япон	23,029.90	-0.75% ▼
Hang Seng	Хонг Конг	23,459.05	0.96% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.95
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.02
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.32
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.43
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	101.36
DBM' 2023	USD	7.250%	105.09
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.92

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.146	-0.06 ▼
Libor 3M	0.218	-0.03 ▼
Libor 6M	0.271	-0.01 ▼
Libor 1YR	0.369	-0.01 ▼
US 2YR Bond	0.131	-0.06 ▼
US 3YR Bond	0.151	-0.06 ▼
US 5YR Bond	0.267	-0.05 ▼
US 10YR Bond	0.658	-0.05 ▼

Валютын ханш	2020.10.02	Өөрчлөлт
USD	2,854.92	0.04% ▲
CNY	420.41	0.41% ▲
EUR	3,346.68	0.43% ▲
RUB	36.43	-1.94% ▼
KRW	2.45	0.41% ▲
JPY	27.14	0.22% ▲
CAD	2,145.10	0.41% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,899.84	2.06% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	23.74	3.70% ▲
Зэс	USD/lb.	297.75	0.22% ▲
Нүүрс	USD/MT	60.07	-0.10% ▼
WTI газрын тос	USD/bbl.	37.05	-7.95% ▼
Brent газрын тос	USD/bbl.	39.27	-6.32% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.44	14.02% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VIII	2.10%
Бодлогын хүү	2020.VIII	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VIII	8.73%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	10.84%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VIII	4.13%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	16.93%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VIII	10.44%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 54 компанийн 230.3 сая төгрөгийн 1,615,721 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Тээвэр дархан” /MSE: TEE/ компанийн хувьцаа 14.98%-аар буюу хамгийн ихээр өсөж 8,595.00 төгрөг хүрч хаагдсан бол “Бэрх уул” /MSE: BEU/ компанийн хувьцаа 14.77%-аар буурч 375.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 11.1 сая төгрөгийн 110 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


10-р сарын 02-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,607.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,589.16 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.11%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	110	11,106,020	99,010	101,000	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	230.3	
Зах зээлийн үнэлгээ	2,607,576.5	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,589.16	0.11% ▲
MSE I индекс	8,253.54	-0.62% ▼
MSE II индекс	7,556.80	0.65% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард санхүүгийн нэгдэл	28,906	40,329,653
АПУ	60,237	33,936,285
Бодь даатгал	156,388	17,423,283
Эрдэнэ ресурс девелопмент корп	18,690	16,141,790
Мандал даатгал	376,367	15,950,229

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Тээвэр дархан	8,595.00	14.98% ▲
Баянгол зочид буудал	28,700.00	14.52% ▲
Хэрлэн хивс	48.00	14.28% ▲
Улсын их дэлгүүр	1,403.00	12.06% ▲
Монгол нэхмэл	2,100.00	12.00% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Бэрх уул	375.00	-14.77% ▼
Ган хийц	9,000.00	-14.28% ▼
Багануур	1,000.00	-12.12% ▼
Махимпекс	2,779.00	-8.76% ▼
Ард санхүүгийн нэгдэл	1,346.00	-7.10% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард секюритиз	98,687,803
Голомт Капитал	64,498,137
БиДиСек	55,089,134
Бумбат-Алтай	45,671,940
Ти Ди Би Капитал	34,145,528

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	574.00	610,840.21
Таван толгой	5,790.00	304,931.51
МИК холдинг	12,790.00	264,872.20
Инвекор ББСБ	2,810.00	201,555.45
Говь	198.00	154,462.28

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-НД ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-НД ОЛГОВ



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



### ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох “Үндэсний хувьчлалын сан”-ийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн худалдан авах захиалгыг Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан 2020 оны 10-р сарын 5-ны өдрөөс 2020 оны 10-р сарын 15-ны өдрийн 10:00-16:00 цагийн хооронд хүлээн авахаар боллоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

**Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын ТУЗ-ийн болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт.**

2020 оны 9-р сарын 28-ны өдрөөс 10-р сарын 2-ны өдрүүдийн хооронд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас 12 хувьцаат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д орсон өөрчлөлтүүд бүртгэгдсэн байна.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт орсон компаниуд:

“Женко тур бюро” /MSE: JTB/ ХК, “Сонсголон бармат” /MSE: SSG/ ХК, “Их барилга” /MSE: IBA/ ХК, “БиДиСек” /MSE: BDSec/ ХК, “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” /MSE: ERDN/ ХК, “Евроазиа Капитал холдинг” /MSE: SUN/ ХК.

ТУЗ-д өөрчлөлт орсон компаниуд:

“Жуулчин дүти фрий” /MSE: SUL/ ХК, “Монгол даатгал” /MSE: MDIC/ ХК, “Багануур” /MSE: BAN/ ХК, “Оллоо” /MSE: OLL/ ХК, “Их барилга” /MSE: IBA/ ХК, “Монгол шевро” /MSE: MVO/ ХК, “Монголын хөрөнгийн бирж” /MSE: HBJ/ ХК.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

**“АПУ” /MSE: APU/ ХК хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтын хугацаа дууслаа.**

“АПУ” /MSE: APU/ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 8-р сарын 13-ны өдрийн 20/15 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулахаар болсон билээ.

Бүртгэлийн өдөр нь 2020 оны 9-р сарын 2-ны өдөр байсан ба саналын хуудсыг 2020 оны 8-р сарын 21-ний өдрөөс 2020 оны 10-р сарын 2-ны өдрийн 16:00 цаг хүртэл хүлээн авсан.

Хурлаар “АПУ” /MSE: APU/ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох болон “АПУ” /MSE: APU/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох асуудлуудыг хэлэлцэх юм.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК



**“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК-ийн ТУЗ-ийн тогтоол.**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 82-р зүйл, “Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК-ийн дүрмийн 9.6.4, 9.6.23 дахь хэсэг болон компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 9-р сарын 24-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнд үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Худалдаа хөгжлийн банкнаас авсан зээлийн гэрээний хугацааг доорх нөхцөлийн дагуу сунгах эрхийг Гүйцэтгэх захирал О. Болдбаатарт олгосон байна.

Зээлийн хэмжээ	1.4 тэрбум төгрөг
Зээлийн хэлбэр	Овердрафт
Зээлийг сунгаж буй хугацаа	12 сар
Зээлийн хүү, шимтгэл	Зээлийн хүү жилийн 19.2%, зээлийн шимтгэл 1.2 сая төгрөг
Эргэн төлөх нөхцөл	Зээлийн хүүгийн төлбөр сар бүр, үндсэн төлбөр банктай тохирсон нөхцөлийн дагуу
Барьцаа хөрөнгө	1.4 тэрбум төгрөгийн хэвийн зээлийн багц болгон нэмэгдүүлэх болон Харилцах дансны орлого үргэлжлүүлэн барьцаалах

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

“Оюу Толгой” төслийн хөрөнгө оруулагч “Turquoise Hill Resources” компани 2020 оны 10-р сарын 1-ний өдрийн мэдэгдэлдээ хувьцаа нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа тухай мэдээлсэн байна. Тус компанийн 10 ширхэг хувьцаа тутмыг нь нэг нэгж болгох бөгөөд 10-р сарын 23-наас хэрэгжиж эхлэх юм.

Тус компанийн 2020 оны 7-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа нэгтгэх эрх болон хэрэгжилтэд хяналт тавих үүргийг ТУЗ-д өгсөн ба Нью-Йоркийн Хөрөнгийн Биржийн бүртгэлийн шаардлагыг хангах зорилгоор хувьцаагаа нэгтгэж байгаа юм.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК



### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын эдийн засгийг энэ онд 2.4 хувиар агшина гэж таамаглаж байгаагаа Дэлхийн банк мэдээллээ.

Өөрөөр хэлбэл цар тахал нүүрлэсэн жил Монгол Улсын эдийн засаг 2009 оноос хойш анх удаагаа агшихаар байгаа юм. Нөгөөтээгүүр оны эхний хагаст эдийн засаг 10 орчим хувь агшсантай харьцуулахад эдийн засгийг хурдацтай өсөх төлөвтэй байгааг Дэлхийн банкны ахлах эдийн засагч онцоллоо. Мөн ирэх жил цар тахлын хүнд байдал намжсанаар эдийн засаг 5.6 хувиар өснө гэж тооцоолжээ.

Зүүн Ази, Номхон далайн бүсийг ерөнхийд нь харвал бүс нутгийн эдийн засаг энэ онд 0.9 хувиар өсөхөөр байна. Энэ нь 1967 оноос хойших хамгийн тааруу үзүүлэлт болохоор байгааг Дэлхийн банк тайландаа дурджээ. Бүс нутагтаа БНХАУ хамгийн эрчимтэй сэргэж байна. Тус улсын эдийн засаг энэ онд хоёр хувиар өсөх төлөвтэй байгаа ажээ. Харин ирэх онд 7.9 хувиар эрс тэлэхээр байгаа юм байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанк 2020 оны 9-р сард 2.3 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 17.1 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6.0 тн-р өссөн үзүүлэлт юм. Монголбанкны нийт худалдан авсан 17.1 тн үнэт металлын 15.4 тн нь алт, 1.7 тн нь цагаан мөнгө байна.

2020 оны 9-р сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 123.9 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 154.5 кг үнэт металл худалдан аваад байна. Он гарснаас хойш орон нутаг дахь Монголбанкны 2 хэлтэс нийт 1.4 тн үнэт металл худалдан авлаа.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 9-р сард 176,494.48 төгрөг байлаа.

Эх сурвалж: BloombergTV.mn



### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.